



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 780

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1259 дугаар Захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн 41,500,000.00 (дөчин нэгэн сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Киа оптима маркийн KNAGN412BC5237384 арлын дугаартай 04-13 УНУ улсын дугаартай авто тээврийн хэрэгслийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож төрийн өмчид хүлээн авч Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Одхүү, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгө шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003040

32-r huraldaan.docx